



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/33/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Цэгцтөв Богд Аудит ХХК
Захирал: Н.Цэрэнханд
Утас: 99901517 Цахим хаяг: khandnorov@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0
.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-90
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/329
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

010.10.10.20\Bicheg_Khareg\Yewaan_Bichig\2022\0224 Audit in 2 Газар-11.Docx

001050184

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алданаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>512,880,392.69</u>	<u>838,174,319.49</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	502,639,362.69	837,433,319.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,047,249.20	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	500,592,113.49	837,433,319.49
35	БАРАА МАТЕРИАЛ	10,241,030.00	741,000.00
354	Хангамжийн материал	10,241,030.00	741,000.00
35420	Аж ахуйн материал	4,731,430.00	-
35440	Түлш, шатах тослох материал	260,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	5,249,600.00	741,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>335,536,849.15</u>	<u>267,230,992.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	335,536,849.15	267,230,992.82
392	Биет хөрөнгө	331,066,849.07	264,128,492.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,500,000.00	69,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,583,333.36)	(23,166,666.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	286,003,847.00	312,583,847.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,197,780.34)	(150,950,528.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,597,762.00	120,597,762.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,253,646.23)	(64,435,920.75)
393	Биет бус хөрөнгө	4,470,000.08	3,102,500.12
39301	Програм хангамж	1,470,000.00	1,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(367,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,999,999.92)	(2,999,999.88)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>848,417,241.84</u>	<u>1,105,405,312.31</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>848,417,241.84</u>	<u>1,105,405,312.31</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	848,417,241.84	1,105,405,312.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	96,015,446.35	96,015,446.35
51101	Өмч: - төрийн	96,015,446.35	96,015,446.35
512	Хуримтлагдсан үр дүн	752,401,795.49	1,009,389,865.96
51210	Өмнөх үеийн үр дүн	186,952,214.13	752,401,795.49
51220	Тайлант үеийн үр дүн	565,449,581.36	256,988,070.47
6.	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>848,417,241.84</u>	<u>1,105,405,312.31</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,651,094,078.00	3,854,925,729.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,664,890.00	28,489,759.00
120	Нийтлэг татварын бус орлого	117,664,890.00	28,489,759.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	117,664,890.00	28,489,759.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,385,000.00	4,102,759.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	114,279,890.00	24,387,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,533,429,188.00	3,826,435,970.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,289,701,160.00	1,392,628,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,289,701,160.00	1,392,628,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,243,728,028.00	2,433,807,570.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	973,898,550.00	1,176,375,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,842,102.00	516,618,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	268,987,376.00	740,813,670.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,085,644,496.64	3,597,937,658.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,085,644,496.64	3,597,937,658.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,945,879,149.38	3,482,495,469.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	979,592,725.27	1,307,711,836.02
210101	Үндсэн цалин	758,029,721.27	1,087,010,936.02
210102	Нэмэгдэл	183,814,671.00	183,828,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,748,333.00	36,872,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,087,762.97	152,009,823.71
210201	Тэтгэврийн даатгал	91,839,662.97	119,313,723.71
210202	Тэтгэмжийн даатгал	8,062,000.00	8,174,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,449,600.00	6,539,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,612,400.00	1,634,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,124,100.00	16,348,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,605,453.30	62,431,207.00
210401	Бичиг хэрэг	23,406,275.00	7,360,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,560,000.00	5,762,567.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,898,899.30	9,463,800.00
210404	Ном, хэвлэл	19,933,110.00	24,639,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,807,169.00	5,964,900.00
210408	Бараа материал акталсны зардал	-	9,240,030.00
2105	Нормативт зардал	21,972,880.00	116,700.00
210502	Хоол, хүнс	21,972,880.00	116,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,489,000.00
210604	Урсгал засвар	-	7,489,000.00
210702	Дотоод албан томилолт	2,273,284.00	38,916,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,012,224,991.00	1,542,719,083.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,005,224,991.00	1,528,344,368.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	13,912,105.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	143,100.00

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	213,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	106,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	743,122,052.84	371,101,419.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	673,002,981.51	276,215,563.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,119,071.33	94,885,856.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,765,347.26	115,442,189.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,422,378.00	95,413,818.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,612,378.00	92,363,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,810,000.00	3,050,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,342,969.26	20,028,371.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,228,782.26	17,664,771.38
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	32,114,187.00	2,363,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	<u>565,449,581.36</u>	<u>256,988,070.47</u>
5	НИЙТ ҮР ДҮН	<u>565,449,581.36</u>	<u>256,988,070.47</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12 дугаар сарын 01-нээрх үлдэгдэл	96,015,446.35	-	186,952,214.13	282,967,660.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35		186,952,214.13	282,967,660.48
Өмчид гарсан өөрчлөлт				
Тайлант үеийн үр дүн	-	-	565,449,581.36	565,449,581.36
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35	-	752,401,795.49	848,417,241.84
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	96,015,446.35	-	752,401,795.49	848,417,241.84
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,015,446.35	-	752,401,795.49	848,417,241.84
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-	
Тайлант үеийн үр дүн	-	-	256,988,070.47	256,988,070.47
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,015,446.35		1,009,389,865.96	1,105,405,312.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,542,014,188.00	4,331,130,842.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,385,000.00	4,102,759.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,385,000.00	4,102,759.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,385,000.00	4,102,759.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,385,000.00	4,102,759.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,538,629,188.00	4,327,028,083.49
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,289,701,160.00	1,392,628,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,289,701,160.00	1,392,628,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,248,928,028.00	2,934,399,683.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	973,898,550.00	1,676,967,113.49
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,842,102.00	516,618,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	274,187,376.00	740,813,670.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,518,735,188.00	4,328,937,842.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,518,735,188.00	4,328,937,842.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,878,377,727.25	3,376,062,333.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	981,639,974.47	1,305,664,586.82
210101	Үндсэн цалин	760,076,970.47	1,084,963,686.82
210102	Нэмэгдэл	183,814,671.00	183,828,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,748,333.00	36,872,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,087,762.97	152,009,823.71
210201	Тэтгэврийн даатгал	91,839,662.97	119,313,723.71
210202	Тэтгэмжийн даатгал	8,062,000.00	8,174,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,449,600.00	6,539,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,612,400.00	1,634,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,124,100.00	16,348,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,175,853.30	52,931,177.00
210401	Бичиг хэрэг	23,406,275.00	7,360,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,820,000.00	5,502,567.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,898,899.30	9,463,800.00
210404	Ном, хэвлэл	19,933,110.00	24,639,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,117,569.00	5,964,900.00
2105	Нормативт зардал	21,972,880.00	116,700.00
210502	Хоол, хүнс	21,972,880.00	116,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,489,000.00
210604	Урсгал засвар	-	7,489,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,273,284.00	38,916,400.00
210702	Дотоод албан томилолт	2,273,284.00	38,916,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,012,224,991.00	1,542,719,083.09

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,005,224,991.00	1,528,344,368.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	13,912,105.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	213,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	106,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	673,002,981.51	276,215,563.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	673,002,981.51	276,215,563.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	640,357,460.75	952,875,508.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,422,378.00	95,413,818.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,612,378.00	92,363,418.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,810,000.00	3,050,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	552,935,082.75	857,461,690.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	552,935,082.75	17,664,771.38
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	532,706,300.49	839,796,919.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,279,000.00	2,193,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	23,279,000.00	2,193,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,279,000.00	2,193,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,279,000.00	2,193,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,279,000.00	2,193,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(23,279,000.00)</u>	<u>(2,193,000.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,392,628,400.00	1,379,066,387.62	13,562,012.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,392,628,400.00	1,379,066,387.62	13,562,012.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,293,824,100.00	1,283,652,569.62	10,171,530.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,402,700.00	847,118,710.82	283,989.18
210101	Үндсэн цалин	626,701,800.00	626,417,810.82	283,989.18
210102	Нэмэгдэл	183,828,700.00	183,828,700.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,872,200.00	36,872,200.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,399,400.00	111,415,430.71	2,983,969.29
210201	Тэтгэврийн даатгал	81,703,300.00	78,719,330.71	2,983,969.29
210202	Тэтгэмжийн даатгал	8,174,000.00	8,174,000.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,539,200.00	6,539,200.00	-
21,204	Ажилгүйдлийн даатгал	1,634,800.00	1,634,800.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	16,348,100.00	16,348,100.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	30,024,600.00	29,354,117.00	670,483.00
210401	Бичиг хэрэг	6,264,600.00	6,069,600.00	195,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,720,000.00	1,719,607.00	393.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,903,800.00	7,903,800.00	-
210404	Ном, хэвлэл	10,692,300.00	10,217,210.00	475,090.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,443,900.00	3,443,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,500,000.00	7,489,000.00	11,000.00
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,489,000.00	11,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,546,400.00	208,811,312.09	1,735,087.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,979,400.00	204,348,702.09	1,630,697.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	152,500.00	143,100.00	9,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,500.00	213,510.00	1,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	199,000.00	106,000.00	93,000.00

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,951,000.00	79,463,999.00	4,487,001.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	83,951,000.00	79,463,999.00	4,487,001.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,804,300.00	95,413,818.00	3,390,482.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,804,300.00	95,413,818.00	3,390,482.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	95,753,900.00	92,363,418.00	3,390,482.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,050,400.00	3,050,400.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,392,628,400.00	1,379,066,387.62	13,562,012.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,392,628,400.00	1,374,963,628.62	17,664,771.38
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		4,102,759.00	(4,102,759.00)
122005	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,392,628,400.00	1,374,963,628.62	17,664,771.4
6	Байгууллагын тоо	1	1	
61	Ажиллагсдын тоо	57	57	
62	Удирдах ажилтан	2	2	
62001	Гүйцэтгэх ажилтан	54	54	
62002	Үйлчлэх ажилтан	1	1	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,934,399,683.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	2,934,399,683.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,094,602,764.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	458,545,876.00
210101	Үндсэн цалин	-	458,545,876.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	40,594,393.00
210201	Тэтгэврийн даатгал	-	40,594,393.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	23,577,060.00
210401	Бичиг хэрэг	-	1,290,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,782,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,560,000.00
210404	Ном, хэвлэл	-	14,422,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,521,000.00
2105	Нормативт зардал	-	116,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	38,916,400.00
210702	Дотоод албан томилолт	-	38,916,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,335,506,771.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,325,594,666.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	9,912,105.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	197,345,564.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	197,345,564.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	839,796,919.49
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	839,796,919.49
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,934,399,683.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,934,399,683.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,676,967,113.49
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	516,618,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	740,813,670.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 10-ны хооронд “Цэгцтөв Богд Аудит” ХХК-ийн ахлах аудитор Г.Цэцэгмаа, аудиторын туслах Б.Мөнхнаран нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Д.Өлзий-Орших хэрэгжүүлсэн.

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсролын хүрээлэн нь боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх, орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг явуулдаг, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

БШУС-ын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 тоот тушаалаар шинэчилсэн баталсан Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх хүрээний байгууллагад мөрдөх НБББББ байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,085,644.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 61,712.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 46,284.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж суурь үзүүлэлтээр тооцсон өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тайлант оны зардал 506,561.7 мянган төгрөг буюу 14.1 хувиар өссөн тул дахин тооцох шаардлагатай гэж үзлээ.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,592,206.2 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 71,844.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 256,988.0 мянган төгрөгөөр буюу 23.2 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	502,639.4	837,433.3	334,479.4
Бараа материал	10,241.0	741.0	(9500.0)
Үндсэн хөрөнгө	335,536.8	267,231.0	(68,305.8)
НИЙТ ХӨРӨНГӨ	848,417.2	1,105,405.3	256,988.0
Засгийн газрын хувь оролцоо	848,417.2	1,105,405.3	256,437.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	848,417.2	1,105,405.3	256,988.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараахь өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс өмнөх оны татаас санхүүжилтийн авлага, Тогтвортой хөгжлийн төсөл-II төслийн 629,060.8 мянган төгрөг, Боловсролын чанарын шинэчлэл төслийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах бие даан суралцах 203,572.5 мянган , Баян-Өлгий аймгийн багш нарыг чадавхжуулах 2022 оны 1-р улиралд хийгдэх сургалтын зардал 4,800.0 мянга, нийт 334,479.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Бараа материал данс эхний үлдэгдлээс бараа материалыг акталж устгасан 9,500.0 мянган төгрөгөөр буурсан
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 256,437.7 мянган төгрөгөөр буурсан.

Боловсролын хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 203,831.6 мянган төгрөг буюу 52.9 хувиар өссөн, бусдаар гүйцэтгүүлэх зардал 530,494.1 мянган төгрөгөөр өссөн Швейцарын Элчин сайдын яамны хамтын ажиллагааны газар болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам хоорондын №81064206 тоот гэрээний дагуу Тогтвортой хөгжлийн төсөл-II төсөл хэрэгжсэнтэй холбоотой.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Боловсролын хүрээлэн нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,951,414.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,951,414.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 628,208.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,323,206.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Үүнээс ном бүтээл хэвлүүлэх , эрдэм шинжилгээ, судалгаа хийх, ажилтан албан хаагчдаа эрүүл мэндийн багц үзлэг хийлгэх, гадаад дотоод эрдэм шинжилгээний хуралд оролцож туршлага судлах санал оруулсан боловч санхүүжүүлэх боломжгүй гэж үзэн нэмээгүйгээс хангамж, бараа материалын зардлыг 15,943.7 мянга, эд хогшил, урсгал засврын зардлыг 19,242.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 593,022.5 мянга, нийт 628,208.2 мянган төгрөгийг бууруулж баталсан.

Тус хүрээлэн нь эрдэм шинжилгээ, судалгаа хийх, гадаад дотоод эрдэм шинжилгээний хуралд оролцож туршлага судлахаар бараа үйлчилгээний бусад зардлын санхүүжилтийг нэмж тодотгох хүсэлт тавьж шийдвэрлүүлснээс шалтгаалж батлагдсан төсвөөс 69,422.3 мянган төгрөгөөр нэмж төсвийг тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,392,628.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,374,963.6 төгрөг улсын төсвөөс санхүүжүүлж авч үндсэн үйл ажиллагааны өөрийн орлого 4,102.7 мянган төгрөг нийт 1,379,066.4 мянган төгрөгийг зарцуулж, 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,379,066.4 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 3,267.8 мянга, хангамж бараа материалын зардлыг 670.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,000.0 мянга, хичээл үйлдвэрлэл дадлагын зардлыг 4,487.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн

зардлыг 1,735.1 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 3,390.5 мянга, нийт 13,562.0 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөтөлбөр арга хэмжээний төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 8,545.1 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 3,390.5 мянга, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ 1,626.4 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	1,296,874.5	1,286,703.0	10,171.5	99,2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,119,262.7	1,110,717.6	8,545.1	99.2
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	98,804.3	95,413.8	3,390.4	96.6
1.3	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	174,561.4	172,935.0	1,626.4	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гадаадын төсөл хөтөлбөрөөс орж ирсэн санхүүжилт 1,676,967.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 516,618.9 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 740,813.7 мянга нийт 2,934,399.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 499,140.3 мянга, хангамж бараа материалын зардалд 23,577.1 мянга, номиативт зардалд 116.7 мянга, албан томилолтын зардалд 38,916.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,335,506.8 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 197,345.6 мянга, нийт 2,094,602.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 839,796.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 837,433.3 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 98.8 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.8 биелэлттэй, 0.9 хувь буюу 13,562.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсөвлөсөн төсвийг төслийн нэгжид албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй холбоотой тайлбар тодруулга авахгүй төсвийг үндэслэлгүй хасч төрийн сангийн системд орууж байна. Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайланд 837,433.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлэх шилжүүлгийг буцаан авахаар авлагаар бүртгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Боловсролын хүрээлэн нь нийт 156 мэдээллийн 4,436,489.2 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4,436,489.2 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Батлагдсан төсвийн урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах Албан шаардлага хүргүүлэх

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 77,742.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, жилийн эцсийн аудитаар дахин хянахад байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам байхгүй гэсэн зөвлөмж биелээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 219.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 37,055.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 9,109.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөнөөс бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	9,109.7	3	9,109.7	-	-	100
Төлбөрийн акт	1	219.4	1	219.4			100
Албан шаардлага	1	37,055.0	1	37,055.0		-	100
Нийт дүн	5	46,384.1	5	46,384.1	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус хүрээлэнгийн Швейцарын Элчин сайдын яамны хамтын ажиллагааны газар болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам хоорондын гэрээний дагуу Тогтвортой хөгжлийн төсөл-II төслийн санхүүжилт 629,060.8 мянга, Боловсролын чанарын шинэчлэл төслийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах бие даан суралцах 203,572.5 мянга, Баян-Өлгий аймгийн багш нарыг чадавхжуулах 2022 оны 1-р улиралд хийгдэх сургалтын зардал 4,800.0 мянга, нийт 837,433.3 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын зарцуулалтыг анхаарах гол асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,240.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 9,240.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн саналын дагуу хүрээлэнгийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/62 тоот тушаалаар 9,240.0 мянган төгрөгийн акталсан бараа материалыг үр дүнгийн тайлан болон тодруулгад зөрүүтэй тайлагнасан.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам баталж ажиллаагүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол "Нийтлэг журам батлах тухай" Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Боловсролын хүрээлэн	АХГ-2022/33/Н А-СТА-ТШЗ	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам баталж ажиллаагүй	дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам баталж ажиллах	1	0									1	0
2	Боловсролын хүрээлэн	АХГ-2022/33/Н А-СТА-ТШЗ	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн саналын дагуу хүрээлэнгийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/62 тоот тушаалаар 9,240.0 мянган төгрөгийн акталсан бараа материалыг үр дүнгийн тайлан болон тодруулгад зөрүүтэй тайлагнасан	Аудитын явцад залруулсан	1	9,240.0	1	9,240.0								
Дүн					2	9,240.0	1	9,240.0							1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Боловсролын хүрээлэн	АХГ-2022/33/Н А-СТА-ТШЗ	Батлагдсан төсвийн урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	1	0					1	0				
Дүн					1	0					1	0				
ИЙТ ДҮН					3	9,240.0	1	9,240.0		0	1	0	0		1	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 өдөр 119/А0150058
АХГ-2022/33/НА-СТБ-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсролын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчлж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн зуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын хүрээлэнгийн захирал П.Лхагвасүрэн, ерөнхий нягтлан бодогч Б.Цэрэнханд нарт даалгаа.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Г.ЦЭЦЭГМАА



